



МОНГОЛ УЛСЫН  
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 287

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, мөн зүйлийн 4 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 208 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн 2023 оны 2023/08 хурлаас гарсан шийдвэр болон түдгэлзүүлэхтэй холбоотой хуульд заасан хугацаанд тайлбар, баримтаар ирүүлээгүй, ирүүлсэн ч шаардлага хангаагүй хавсралтад дурдсан 4 /дөрөв/ хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаанд түдгэлзүүлсүгэй.

2. Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэхтэй холбоотой явцын мэдээлэл, шийдвэрийг зөвшөөрлийн нэгдсэн санд бүртгүүлэхийг, мөн энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газар (Э.Батболд)-т тус тус даалгасугай.


4. Энэхүү тушаалыг эс зөвшөөрвөл 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.



Ц.ДАВААСҮРЭН

152310708

Барилга, хот байгуулалтын сайдын  
2023 оны 12 дугаар сарын 06-ны  
өдрийн 287 дугаар тушаалын г хавсралт



**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ТҮДГЭЛЗҮҮЛСЭН ХУУЛИЙН  
ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Регистрын дугаар	Түдгэлзүүлсэн тусгай зөвшөөрлийн төрөл	Түдгэлзүүлсэн үндэслэл
1	"ПУГАМЭП" ХХК	5743184	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	Геодезийн инженер өөр аж ахуйн нэгжид ажилд орсон
2	"Максимал" ХХК	5459508	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	Геодезийн инженер өөр аж ахуйн нэгжид ажилд орсон
3	"Техно кад" ХХК	6541623	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	Геодезийн инженер өөр аж ахуйн нэгжид ажилд орсон
4	"Медиатор шип" ХХК	6332811	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	Байрлал болон өндрийн хэмжилт хийх хэмжилтийн багаж баталгаажуулалтын хугацаа 2022.09.03-ны өдөр дууссан

--- оОо---